

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**ПОЛЬШ-МОНГОЛЫН ХАРИЛЦАА
(1950—1982 ОНД)**

Стефан Койло. Польшийн ШУА,
социалист орнуудыг судлах
хүрээлэнгийн эрдэмтэн

Польш, Монголын хоорондын харилцаа 32 илүү жилийн турш амжилттай хөгжин цэцэглэж манай хоёр ард түмний сайн сайхны төлөө, социалист нөхөрлөлийн орнуудын найрамдал, олон улсын коммунист ба ажилчны хөдөлгөөний эв санааны нэгдлийн ашиг тусын төлөө үйлчилж байна.

Шинэ нийгмийг байгуулах нэг нэгдсэн зорилго, Польшийн ажилчны нэгдсэн нам, Монгол ардын хувьсгалт намын зарчимч чиг шугам, польш, монголын ард түмнээс Зөвлөлт Холбоот Улс ба ах дүү бусад орнуудтай байгуулсан найрамдал, интернационалч эв санааны нэгдэл нь монгол-польшийн бүх талын хэлхээ холбоог хөгжүүлэх найдвартай үндэс суурь мөн.

1950 оны 4-р сарын 14-нд Бүгд Найрамдах Польш Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс дипломат харилцаа тогтоосноор улс төр, эдийн засаг, соёл боловсрол болон бусад талбарт харилцаа холбоо, хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх эхин тавигдсан ажээ.

Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан ойлголцох явдлыг тогтоон хөгжүүлэхэд 50-иад оны дундаас эхэлсэн польш-монголын дээд хэмжээний уулзалт чухал роль гүйцэтгэжээ. 1954 онд БНМАУ-ын засгийн газрын төлөөлөгчид нөхөр Ю. Цэдэнбалаар толгойлуулан БНПАУ-ын 10 жилийн ойд оролцож, Болеслав Берут тэргүүтэй польшийн нам, засгийн төлөөлөгчид БНМАУ-д айлчлан очсон билээ. Тэр цагаас хойш өнөөдөр хүртэл манай хоёр орны ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа тууштай өргөжин хөгжиж тэдгээрийн эдийн засгийн хүчин чадал, соёлын ололтыг зузаатгах хэрэгт тус дөхөм болсоор байна.

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

1975 оноос польш-монголын харилцаа БНПАУ, БНМАУ-ын хоорондох найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ бичигт тулгуурласан ба түүнд хоёр тал социалист нөхөрлөлийн нэгдэл нягтралыг бэхжүүлж польш-монголын ард түмний ойртон нягтрах явдалд зориг төгс байгаагаар санал нэгтэй илэрхийллээ. Бид манай олон талт хамтын ажиллагаа, түүний дотор шинжлэх ухааны талбарт амжилттай хөгжиж байгаа нь Польшийн Ажилчны Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам түүний Төв Хороодын хүчин чармайлт, анхаарал халамжийн үр дүн мөн гэж бат хэлж болно.

Тус хоёр орны хамтын ажиллагааны хамгийн баялаг туршлага худалдааны талбарт хуримтлагдсан бөгөөд уул худалдаа 1957 оны 3-р сард байгуулагдсан хэлэлцээрээр эхэлсэн юм. Өнгөрсөн 24 жилийн дотор БНПАУ, БНМАУ-ын хоорондох гадаад худалдааны гүйлгээ 25 дахин нэмэгдлээ. Мөн таваарын гүйлгээний зохион байгуулалт нилээд өөрчлөгдсөн нь тус хоёр орны гүйцэтгэж буй ээлжит зорилго, эдийн засгийн зохион байгуулалтын өөрчлөлттэй тохирч байна.

1982 онд БНМАУ-д Польшоос нийлүүлсэн импортын тэн хагас нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, нөгөө хагас нь өргөн хэрэгцээний үйлдвэрийн бараа таваар, түүний дотор гоо сайхны зүйл юм. Монголоос Польшид мал аж ахуйн гаралтай түүхий эд (46,6%), махны бүтээгдэхүүн (24,6%), үйлдвэрийн бараа таваар (28,8%) түүний дотор хивс, шевро, шеврет, савхин эдлэл зэргийг экспортлоно. Польшоос импортлосон бүх зүйлс 5,8 сая рубль, Монголоос экспортолсон нь 7-3 сая рубль хүрчээ.

Манай хоёр орны хоорондын харилцааг тодорхойлдог социалист интернационализмын илрэл нь, жишээ нь БНМАУ-аас Польшид 1961 оны эцсээр 2 мянган тонн мах нийлүүлсэн явдал мөн.

Польш-монголын эдийн засгийн хамтын ажиллагааны эхин нь Монгол хөгжлийнхөө шинэ шат-тус орныг үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон хувиргахад чухлаар шаардагдах материал-техникийн баазыг шамдан байгуулах шатанд шилжин орсонтой тохирч байна.

Энэ хамтын ажиллагаа хөгжихөд Монгол улс ЭЗХТЗ-ийн гишүүнд элссэн явдал түлхэц өглөө.

Манай орнууд 1961—1981 оны турш хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж Польшоос Монголд эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх гурван хэлэлцээр байгуулсан.

Польшоос Монголд олгох зээлийн хэлэлцээр ёсоор зарим нэг үйлдвэрийн газарт зориулан иж бүрэн тоног төхөөрөмж, барилгын зарим нэг машин, материал, техникийн зураг төслөөр хангаж, мэргэжилтэн явуулж, тэнд баригдаж буй барилга байгууламжид ажиллах инженер-техникийн боловсон хүчнийг бэлтгэж, баригдаж буй барилга байгууламжийг эхлүүлж, үйлдвэрийн хүчин чадлыг нь ашиглах мэргэжилтэн зөвлөх нарыг томилон илгээдэг.

Манай орнуудын эдийн засгийн хэлхээ холбоо өргөжиж байгаа нь монголын аж үйлдвэрийн хөгжилд тус дөхөм болж байна. БНМАУ-д БНПАУ-ын үзүүлж буй тусламж, тухайлбал, барилгын материалын үйлдвэр, мод боловсруулах, хөнгөн хүнсний, эрчим хүчний үйлдвэрийн салбаруудыг хамрана.

Тэмдэглэлтэй нь, польш-монголын хамтын ажиллагааны үр дүнд Монголд барилгын материалын орчин үеийн үйлдвэр байгуулагдан хөгжиж ирсэн нь социалист эдийн засгийн материал техникийн баазыг өрнүүн байгуулахад чухал ач холбогдолтой.

Польш, монголын мэргэжилтний хамтын хүчээр байгуулагдан ажиллаж байгаа зарим үйлдвэрийн газрууд тэргүүний эгнээнд явж байна. Үүний сайхан жишээг Дарханы царууц тоосгоны комбинат үзүүлж байгаа ба эдийн засгийн сайн үзүүлэлтэд хүрч чанар сайтай бүтээгдэхүүн нь Монголын хилийн чанадад ч үнэлэгдэх боллоо.

Дарханы царууц тоосгоны комбинат иь хамтын хүчээр байгуулсан өөр бусад барилга, байгууламжуудын адил зөвхөн барилгын үйлдвэрийн бааз суурь төдийгүй, польш-монголын найрамдал, хамтын ажиллагааны билэг тэмдэг болж байна.

Польшийн техникийн туслалцаатайгаар Монголд байгуулагдсан үйлдвэрүүдээс Улаанбаатарын мод боловсруулах комбинат, бетон, цавуу, спирт үйлдвэрлэх заводуудыг нэрлэж болох юм. Мөн түүнчлэн цахилгаан станц, эртний Хархорин хотод спиртын завод байгуулагдлаа.

Польш-монголын эдийн засгийн үр бүтээлтэй хамтын ажиллагааны бас нэг шинэ илрэл нь газар тариалангийн шинэ иж бүрэн аж ахуйнуудыг барихаар төлөвлөсөн зүүн зүгийн эдийн засгийн районы төв-Чойбалсан хотод жилд 30—40 сая ширхэг туйпуу үйлдвэрлэх чадалтай тоосгоны завод байгуулагдсан байгаа явдал юм.

Польш-монголын эдийн засгийн хамтын ажиллагаа нь монголын эдийн засгийн үндсэн салбар-хөдөө аж ахуй, ялангуяа мал эмнэлгийн албыг мөн хамардаг юм. Польшийн малын эмч нар 1966—1968 онд ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас Монголд мал сүргийн урьдчилан сэргийлэх үзлэг явуулахад оролцов.

1977—1980 онд мал эмнэлгийн талаар хамтын ажиллагаа гурван үндсэн чиглэлээр явагдсан. Үүнд а) мал сүргийн өвчинг сэргийлэх ба анагаах, б) малын сувайралттай тэмцэх, в) мал эмнэлгийн ариун цэврийн хяналт тогтоох зэрэг болно. Монголын малын эмч нарыг давтан сургах ба мэргэжлийг дээшлүүлэх, мөн монголын мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлэх асуудал эрхэлсэн польш-монголын арга зүйн хамтарсан комисс үр бүтээлтэй ажиллаж байна.

1961—1965 онд монголын баруун аймгуудад польш-монголын геологийн экспедици ажиллаж Их Нууруудын хотгорын район, Алтай, Ховд, Улаангом хотын орчин тойронд геологийн урьдчилсан судалгаа шинжилгээ хийлээ. 1976 оноос польшийн геологчид Монголын нутаг дэвсгэр дээр ажилладаг Олон улсын геологийн экспедицид оролцож байна.

Үүнээс гадна, Польш, Монгол хоёр 1931 оны 4-р сард 2000 он хүртэл геологи шинжилгээний хамтарсан ажил явуулах минералын түүхий эдийг олзворлон ашиглаж боловсруулах талаар ерөнхий хэлэлцээр байгуулснаар манай цаашдын хамтын ажиллагаанд шинэ төлөв нээгдлээ.

Польш-монголын эдийн засгийн хамтын ажиллагаа нь социалист нөхөрлөлийн орнуудын нийтээр даган мөрддөг хоёр талын зохион байгуулалтын хэлбэрээр явагддаг бөгөөд энэ нь а) хоёр орны ардын аж ахуйг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөг уялдуулан зохицуулах, б) эдийн засаг, шинжлэх ухаан техникийн талаар хамтран ажиллах хоёр талын засгийн газар дундын комиссыг ажиллуулах явдал мөн. Польш-монголын комисс 1972 оноос ажиллаж байна. 1981 оны 4-р сар хүртэл тэр комиссын 9 чуулган болж өнгөрлөө.

1961 онд Польш, Монголын хооронд шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах гэрээ байгуулагдаж хоёр тал шинжлэх ухаан техникийн зураг төсөл, техникийн ба үйлдвэрлэлийн туршлага, мэргэжилтэн солилцож боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх талаар ажил зохиож ирлээ.

Монголын мэргэжилтнүүд Варшавт очиж гэрлийн техникийн мэргэжил эзэмшсэнээр Улаанбаатар хотын гэрлийн чимэглэлийн үр нөлөө нэмэгдлээ. Хоршооллын байгууллагын ажилтны техник-мэргэжлийг дээшлүүлэх талаар сайхан уламжлал тогтож байна.

Польшоос Монголд үзүүлсэн санхүүгийн хөрөнгөөр 1979 онд Улаанбаатарт ноос боловсруулах үйлдвэрийн дэргэд эрдэм шинжилгээний лаборатори байгуулагдлаа. Энэ лаборатори нь үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, монголын ноосон ба бүс даавуу эдлэлийн чанар, нэр төрлийг сайжруулахад тус дөхөм үзүүлж энэ талбарт хамтран ажиллахын эхлэлт боллоо.

Монголын мэргэжилтнүүд нь польшийн анд нөхдөөсөө ариун цэврийн хяналт тавих албыг зохион байгуулах туршлагатай танилцсан явдал чухал юм.

Манай хоёр орон соёлын талаар бараг хорин таван жил хамтран ажиллаж ирэв. 1958 онд байгуулсан гэрээ ёсоор хоёр тал соёлын зүтгэлтэн, уран зохиолчид, хөгжимчид тэргүүтнийг солилцон харилцан уран зураг, ухуулах хуудас фото зургийн үзэсгэлэн зохион байгуулж байна. Соёлын хамтын ажиллагаа амжилттай хөгжиж ирсэн нь уул гэрээний хүрээнээс хальж гарсан тул, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай боллоо. 1977 онд манай хоёр орон соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны талаар шинэ гэрээ байгуулав. 1975 оноос энэ талын хамтын ажиллагаа таван жилийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан юм. Энэ гэрээний салшгүй хэсэг нь БНПАУ, БНМАУ-ын уран бүтээлийн эвлэл холбоонууд болон соёлын бусад байгууллагуудын хооронд байгуулагддаг хэлэлцээрүүд боллоо. Соёл, шинжлэх ухааны төлөвлөгөөг тус хоёр орны хооронд 1976—1980 онд биелүүлэхэд БНПАУ-ын Гадаад явдлын Яамнаас гадна, 15 яам, төвийн болон уран бүтээлийн бусад байгууллагууд оролцсон юм.

Соёлын олон жилийн хамтын ажиллагааны үр дүнд манай хоёр орны ард түмэн соёл, урлагийн бүтээл солилцож харилцан оюун санаагаа баяжуулж ирлээ.

Жишээ нь, польш хэлээр «Монголын нууц товчоо», Б. Явуухулангийн яруу найраг, Ц. Дамдинсүрэнгийн туужууд, Ч. Лодойдамбын «Тунгалаг Тамир» роман зэрэг орчуулагдан гарав. Мөн польшийн олон уншигчид нь польшийн зохиогчдын бичсэн өгүүлэл, нийтлэл болон эрдэм шинжилгээний зохиолуудаар дамжуулан монголын ард түмний амжилт ололттой танилцсаар байна.

Бидний мэдэж байгаагаар монгол хэлээр В. Броневский, Ю. Тувим, Э. Шельбург-Зарембина, Е. Анджеевский, С. Шмаглевская, Г. Сенкевич, Б. Прус, Я. Иванкевич мөн А. Мицкевич нарын зохиол орчуулагдсан байна. Сүүлийн үед польшийн уран зохиолын «Наранцэцэг» гэдэг 28 зохиолчдын 78 зохиолоос бүрэлдсэн түүвэр монгол уншигчдын дотор ихэд түгэв. Монголын олон үзэгчид ялангуяа залуучууд «Аминаас чухал үйлс», «Нохойтой дөрвөн танкчин», «Загалмайтан», «Хубаль болон бусад» гэх зэрэг киног ихэд сонирхон үздэг юм. Польшийн үзэгчид монголын кино урлагт түүхийн үйл явдлыг харуулсан «Эх бүрдийн домог», «Цогт тайж» зэрэг киног сонирхон үздэг.

Монголд польшийн ансамбль «Сленок», «Мазовше», эстрадын ансамблиуд, мөн Анна Герман зэрэг нэрт дуучид ирж тоглож байв. Польшийн олон үзэгчид «Соёл эрдэнэ» зэрэг монголын эстрадын ансамблиудын тоглолтыг сонирхлоо. Улаанбаатар хотын циркийн олон улсын «Найрамдал» программд польшийн жүжигчид оролцож тоглох нь сайхан уламжлал болсон билээ. Соёлын хамтын ажиллагааны сүүлийн нэг хэлбэр нь монголын жүжигчид Бельск-Бяла хотонд болсон хүүхэлдэйн театруудын наадамд оролцсон явдал мөн.

Польшууд Монгол орныг сонирхдогийг олон баримт нотлоно. Үүнд харилцан жуулчлагчдыг солилцох явдал амжилттай үргэлжилж байгаагаас гадна, Польшид анх 24 мянган ширхэг хэвлэсэн Монголын тухай жуулчны гарын авлагыг номын дэлгүүрээс хурамхан зуур худалдан авчээ.

Польшийн Шинжлэх ухааны Академи, БНМАУ-ын Шинжлэх ухааны Академийн хооронд 1961 оны 9-р сарын 19-нд байгуулсан хэлэлцээрийн дагуу 1961 оноос тус хоёр орны хооронд шинжлэх ухааны талаар хамтран ажиллах явдал хөгжиж байна.

Эхний жилүүдэд энэ талын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний ажилтнууд ба шинжлэх ухааны зохиол солилцох хэлбэрээр үндсэндээ явагддаг байлаа. Харин 1963 оноос палеонтологи, этнографийн талаар хамтран ажиллах явдал эхэллээ. 1963—1971 оны завсар польш, монголын палеонтологчид хээрийн шинжилгээний ангийг 8 удаа хамтран зохион явуулав. Олзворлосон материал нь өнөөдрийг өдөр хүртэл польш, монголын эрдэмтдийн эрдэм шинжилгээний ажилд хэрэглэгдсээр байна. Энэ талаар хэвлэсэн зохиолууд эрдэм шинжилгээний их ач холбогдолтой.

1963 оноос этнографийн талаар хамтран ажиллах боллоо. 1965—1980 онд хээрийн шинжилгээ явагдсан юм. 1965—1970 онд хэрхэн уламжлалт соёл иргэншил одоогийн социалист бүтээн байгуулалттай зохицолдож байгаа зүй тогтоолыг судлахад анхаарал тавьжээ. Дараа нь 1971—1975 онд польш, монголын эрдэмтэд малчны мэргэжлийн төлөвшин тогтох нөхцлүүд, хөдөөний залуучуудын нүүдэл хөдөлгөөний учир шалтгааныг шинжлэн судлав. Энэ шинжилгээ судалгааны үр дүн нь БНМАУ-ын нийгэм-эдийн засгийн бодлогын зарим нэг чиглэлийг бий болгоход тодорхой ач холбогдол өгөв.

1977 оноос тус хоёр академи Хангайн районы геоморфологи, глянциологи, усны нөөц судлах талаар газар зүйн хамтарсан судалгаа хийв. Эрдэм шинжилгээний ажлыг польш-монголын шинжилгээний анги, монгол-польшийн эрдэм шинжилгээний станц хамтран явуулдаг юм. Ингэж цуглуулсан материал нь эл районы ардын аж ахуйн үр шимийг дээшлүүлэхэд чухал байгалийн нөөцийг аль болохоор нарийвчлан тооцоолох бололцоо өгнө.

Польш, Монголын эрдэмтдийн ойртон ажиллах бас нэг нөхцөл нь Коперникийн жил (1973 он) болов. Энэ ажлын хүрээнд «Нар барьж, дэлхийг хөдөлгөсөн» энэхүү дэвшилтэт эрдэмтний амьдралтай Монголд улам ойр танилцах боллоо. Баяр ёслолын эцэст Улаанбаатарт Коперникийн хөшөө дурсгал байгуулсан нь Азид босгосон түүний анхны хөшөө болжээ.

1973 оны 9-р сарын 14-нд тус хоёр орны академийн хооронд шинэ гэрээ байгуулагдлаа. 1975 оноос хамтын ажиллагаа таван жилийн төлөвлөгөөгөөр явагдах болов.

БНМАУ-ын шинжлэх ухааны цаашдын хөгжил нь БНПАУ, БНМАУ-ын хооронд шинжлэх ухааны талаар хамтран ажиллах явдалд тус дөхөн үзүүлж байна. 1981—1985 оны харилцан уялдуулсан таван жилийн

төлөвлөгөө ёсоор эрдэм шинжилгээний ажлыг автоматжуулах талаар хамтын ажиллагаа явагдах болно. Үүний зэрэгцээ БНМАУ-ын эдийн засгийн районуудын орон зайн систем, тус орны төв районы байгалийн нөөц, цаг улирлын нөхцлийг судлаж нэгдсэн дүн шинжилгээ гаргана. Мөн түүнчлэн Монголын ажилчин ангийн талаар цуглуулсан материалыг боловсруулж, Монголын динозавр амьтдын тухай палеоэкологийн талаар шинжилгээний хамтын зохиол бичнэ.

Эрдэм шинжилгээний зохиол солилцох явдал манай хамтын ажиллагааны нэг чухал хэлбэр болсон бөгөөд ийм солилцоог Польшийн Шинжлэх ухааны Академи, БНМАУ-ын улсын нийтийн номын сангийн хооронд хийж байна. Бидний бодоход, энэ талаар явуулах хамтын ажиллагаа нь хамтран ажиллагч орны хөгжлийн асуудлуудыг харилцан судлах боломжийг нэмэгдүүлж өгнө.

Монголд явагдсан хувьсгалт өөрчлөлт, одоогийн социалист байгуулалтын тулгамдсан асуудлуудыг польшийн нийгэм судлагчид сонирхон үздэг юм. Монгол дахь социалист байгуулалтын онцлогуудаас гадна тус орыг үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон хувиргахад чухал хэрэгтэй нийгэм-эдийн засгийн баазыг шургуу байгуулах одоогийн шатан дахь түүний нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлуудыг судлахад Польшийн Шинжлэх ухааны Академийн социалист орнуудын судлалын хүрээлэн ихээхэн анхаарал тавьж байдаг юм. Монгол судлалын асуудлаар явуулах эрдэм шинжилгээний ажил энэхүү хүрээлэн дотор Европын бус социалист орнуудын судлалын хэлтэс, Алс Дорнодын социалист орнуудын судлалын тасаг байгуулахад эхин тавьж өгсөн билээ.

Варшав, Улаанбаатарын их сургуулиуд, ялангуяа, Польшид монгол хэлний мэргэжилтэн бэлтгэх талаар олон жил хамтран ажиллаж байна. Үүнд Варшавт монгол лектор явуулж, Улаанбаатарт польш оюутнууд ирж мэргэжилээ дээшлүүлдэг журам тус болж байна.

Мөн Польшид ч 1961 оноос монгол залуус олон мэргэжлээр суралцах болсон юм. 1981—1985 оны соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны төлөвлөгөө ёсоор, польшийн тал, урьдын адил жил бүр 15 оюутан, 3 аспирант, мэргэжил дээшлүүлэх 3 хүнийг үнэ төлбөргүй сургахаар боллоо. Өнөөдөр хүртэл Польшид барагцаалбал 80—100 мэргэжилтнүүд бэлтгэгджээ.

Манай оронд социалист төр улсын үүрэг роль, нийгмийн дэг журам сэргэн тогтож ирэхэд манай хоёр орны хооронд тогтсон олон талт хамтын ажиллагаа шинэ түлхэц өглөө. Манай хоёр орны цаашдын хөгжлийн бат нот үндэс суурь бол марксизм-ленинизм, социалист интернационализмын үндэснээс урган гарч буй манай үзэл суртал, улс төрийн нэгдэл, тус хоёр орон ЭЗХТЗ-ийн гишүүн болсон явдал, мөн Польшийн Ажилчны Нэгдсэн Нам ба Монгол Ардын Хувьсгалт Намаас социализм байгуулах талаар баримталж яваа зарчимт чиг шугам мөн.

Манай хоёр улс марксизм-ленинизм ба социалист интернационализмын үндсэн дээр найрамдалт харилцаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлж байгаа нь польш, монголын ард түмний язгуурын эрх ашиг, социалист нөхөрлөлийн нэгдэл нягтралыг бэхжүүлэх хэрэгт үйлчилж байна.

Тус хоёр орны 32 жилийн найрамдалт харилцаа нь манай түүхчдээс польш-монголын харилцааг судлах ба энэ талаархи баримт бичгүүдийг эмхтгэн бэлтгэх талаар хамтран ажиллах өргөн бололцоо нээж өглөө.

Польшийн Шинжлэх ухааны Академийн социалист орнуудын судлалын хүрээлэнгийн захиргаанаас над өгсөн үүрэг даалгавар ёсоор польш-монголын харилцааны баримт бичиг, материал судлан эмхтгэн хэвлүүлэх польш-монголын хамтарсан комисс байгуулах санал тавьж байна.

Ийм чухал ажил гүйцэтгэх туршлага бидэнд бий. Жишээ нь манай хоёр орны эрдэмтэд Зөвлөлт Холбоот Улс ба социалист бусад орнуудтай ийм хамтын ажиллагаанд оролцож байгаа юм. Манай польшийн хүрээлэн ЗХУ-ын Шинжлэх ухааны Академийн Славян ба Балкан судлалын хүрээлэнтэй хамтран зөвлөлтийн «Наука» хэвлэлийн газраар польш-зөвлөлтийн харилцааны баримт бичгийн эмхтгэл 10 ботийг нэгэнт хэвлэсэн ба одоо 11-р боть нь бэлтгэгдэж байна. Монгол, зөвлөлтийн эрдэмтэдийн хамтын ажиллагааны нэг үр дүн нь монгол-зөвлөлтийн харилцааны баримт бичиг, материалын эмхтгэл 2 ботийг хэвлэн нийтлүүлсэн явдал мөн.

БНМАУ, БНПАУ-ын ах дүүгийн харилцааны түүхийг судлах, баримт бичиг, материалыг эмхэтгэн хэвлүүлэх талбарт манай хоёр орны эрдэмтэд үр бүтээлтэй хамтран ажиллах цаг боллоо.